




**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМАНД “ИХ БУЛАН”
НЭРТЭЙ ГАЗАРТ ОРШИХ ЭЛСНИЙ ОРД ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ.....	4
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	5
2.1. Төслийн нэр.....	5
2.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	5
2.3. Төслийн байршил	5
2.4. Орд ашиглах тусгай зөвшөөрөл	6
2.5. Ордын нөөц	7
2.6. Төслийн хүчин чадал.....	7
2.7. Уурхайн ажиллах горим.....	7
2.8. Тоног төхөөрөмж.....	7
2.9. Уурхайн дотоод тээвэр.....	8
2.11. Цахилгаан хангамж	8
2.12. Автозамын үндсэн элемент	8
БҮЛЭГ 3. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
4.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ.....	15
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд.....	15
4.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
4.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
4.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
4.7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	23

ХҮСНЭГТИЙН ДУГААРЛАЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	5
Хүснэгт 2. Талбайн солбицол.....	6
Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа	7
Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн их бүрдэл.....	7
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	12
Хүснэгт 6. Мод тарих талбайн координат.....	15
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ба түүний зардал.....	17
Хүснэгт 8. Төслийн үйл ажиллагаа явуулах талбайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ба түүний зардал	20
Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22
Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	23
Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	24

ЗУРГИЙН ДУГААРЛАЛТ

Зураг 1. Төслийн байршлын зураг	6
Зураг 2. Мод тарьсан талбай ба түүний байршил	16

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилтыг хангах үүднээс БОАЖЯ-наас байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна .

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь Элс-хайрганы ордын үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн хэрэгжүүлэн ажиллана.

Тус компани Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-г 2019 онд мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэсэн, түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллана.

“Анто-од” ХХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагын тэнцвэрийг олох зарчмаар тогтвортой хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн билээ. Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажиллана.

- Байгаль орчны удирдлагын ISO 14001 стандартад нийцсэн байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн үйл ажиллагааны байнгын хяналт, ахиц дэвшлийг ханган ажиллана;
- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авна.
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлнэ.
- Ашигт малтмалын хайгуул хийх, барилга байгууламж барих, уурхайн олборлолт хийх зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлнэ.
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд туслах зорилгоор ажилчдад сургалт зохион байгуулна.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулна.
- “Анто-од” ХХК өөрийн үйл ажиллагаа болоод төслийн цар хүрээ, нөхцөл байдал хоорондын бодит уялдаа холбоог хангах үүднээс үйл ажиллагааны тогтолцоонд тодорхой хугацаанд хяналт тавьж ажиллана.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Анто-од” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		1911009011
3	Уурхайн нэр		“Дарханы элс-хайрганы ордын Их булан хэсгийн элс-хайрганы орд”-ыг ил аргаар ашиглах төсөл
5	Ордын	Нийслэл/Хот/ Аймаг	Дархан
6	байршил	Сум/Дүүрэг	Орхон
7	Ашигт малтмалын төрөл		Элс-хайрга
8	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		ДА-004А
9	Ашиглалт эхэлсэн огноо		2020
10	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Дархан
11		Сум/Дүүрэг	Дархан
12		Баг/Хороо	Өргөө баг, 21-р хороолол
13		Гудамж/Байр	Өөрийн байр
14		Шуудангийн хайрцаг	-
15		Утас	976-99070804
16		Факс	Antood.llc.@yahoo.com
17		Гар утас	-
18		Электрон шуудан	-
19		Вэб хуудас	-
20	Захирлын хаяг	Нэр	Захирал М.Одончимэг
21		Гар утас	976-991057225
22		Факс	-
23		Утас	-
24		Электрон шуудан	Antood.llc@gmail.com

2.1. Төслийн нэр

Дархан-Уул аймгийн Орхон сумын нутаг дэвсгэрт орших “Дарханы элс-хайрганы ордын Их булан хэсгийн элс-хайрганы орд”-ыг ил аргаар ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“Анто-од” ХХК нь 2008 онд уул уурхайн бусад олборлох үйл ажиллагаа, худалдаа үйлчилгээ, худалдааны зуучлал, газрын хэвлийн нөхөн сэргээлт зэрэг чиглэлээр үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын 1911009011 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 4251679 тоот регистрийн дугаартай.

2.3. Төслийн байршил

“Дарханы Элс-хайрганы ордын Их булан хэсгийн Элс-хайрганы орд” нь Дархан- Уул аймгийн нутагт харъяалагдах ба Улаанбаатар хотоос хойш 235 км, Дархан хотоос баруун хойш 5 км-т Хараа голын хөндийн зүүн өндөр дэнжид байрладаг.

Хүснэгт 2. Талбайн солбицол

№	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	105	56	22.66	49	33	1.84
2	105	56	56.33	49	33	1.84
3	105	56	56.33	49	32	18.4
4	105	56	22.66	49	32	18.4



Зураг 1. Төслийн байршилн зураг

2.4 Орд ашиглах тусгай зөвшөөрөл

Дархан-уул аймгийн засаг даргын тамгын газраас “Анто-од” ХХК-д 90.78гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож ДА-004А дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 06 сарын 03-ны өдөр олгосон.

“Анто-од” ХХК нь Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт орших “Дарханы Элс-хайрганы ордын Их булан хэсгийн Элс-хайрганы орд”-д 2018 онд геологи

хайгуулын ажил, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө зэргийг боловсруулан АМГТГ-ын геологийн хэлтэс, ЭБМЗ-ийн 2019 оны 04 сарын 12-ны хурлаар орж батлуулсан.

УУХҮЯ, АМГТГ азар, ЭБМЗ-ийн хурлаар орж 2019 оны 6-р сарын 27-ны өдөр ТЭЗҮ-ийг батлуулсан.

2.5. Ордын нөөц

Дарханы элс-хайрганы ордын Их булангийн тохойн хэсгийн элс-хайрганы холимгийн ордод бодитой В зэргийн 1,658.9 мян.м³, боломжтой С зэргийн 1,994.3 мян.м³, нийт 3,653.2 мян.м³ элс, хайрганы нөөц тооцоолов.

2.6. Төслийн хүчин чадал

Дарханы элс-хайрганы ордын Их булангийн тохойн хэсгийн элс-хайрганы холимгийн ордод бодитой В зэргийн 1,658.9 мян.м³, боломжтой С зэргийн 1,994.3 мян.м³, нийт 3,653.2 мян.м³ элс, хайрганы нөөц тооцоологдсон байна.

Элс-хайрга олборлолт: 2024оны ажлын хүрээнд В-2 блокоос нийт 27.2 мян.м³ элс-хайрганы холимог олборлох ба тусгайлан бэлдсэн овоолгын талбайд овоолно.

2.7. Уурхайн ажиллах горим

Элс-хайрга олборлолтын ажил 2024 оны 4-р сарын 1-ээс 10 сарын дунд хүртэл хийнэ. Ил уурхай нь улирлын чанартай ажиллана. Уурхай нь хоногт нэг ээлжээр, ээлжинд 8 цаг ажиллана.

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

Үзүүлэлт	Х.н	2024 онд
Жилд ажиллах хуанлийн өдөр	хоног	170
Баяр ёслолын үеийн амралтын өдөр	хоног	6
Засвар үйлчилгээ, цаг агаар болон бусад өдрүүд	хоног	15
Ажиллах өдөр	хоног	149
Нэг хоногийн ээлжийн тоо	хоног	1
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	хоног	8
Ээлж солилцох хугацаа	хоног	0

2.8. Тоног төхөөрөмж

Хөрс хуулалт 2.8м³ шанагатай HITACHI фирмийн 450 маркийн урвуу утгуурт гинжит экскаватор 1ш, элс-хайрга олборлолтонд HLC250 хөвөгч драг ашиглана. Элс тээвэрт 25тн даацтай HOWO 6x4 маркийн автосамосвал 2ш, овоолго үүсгэх хэсэгт ZL-50 маркийн 3.0 м³-ыг хамах чадвартай утгуурт ачигч 1ш ажиллана.

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн их бүрдэл

Ажлын зориулалт	Марк	Хүчин чадал	Тоо, ш
Хөрс хуулалт	HITACHI-450	2.8 м ³	1
Элс-хайрга олборлолт	HLC250	1250 м ³ /h	
Хөрс тээвэрт	HOWO 6x4	25 тн	2

Овоолго	ZL-50Утгуурт ачигч	3 м3	1
Нийт	-		4

2.9. Уурхайн дотоод тээвэр

“Их булан” элс-хайрганы холимогийн ордын хувьд хэвтээ уналтай тул тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем хэрэглэх боломжтой юм.

Уурхайд элс-хайрга тээвэрлэлтийн ажил нь автотээврээр хийгдэнэ. Элс-хайрганы холимогийг уурхайгаас бутлан ангилах хэсэг рүү 300м-с 700м хүртэл жилүүдийн дунджаар 560 м замын урттайгаар тус тус тээвэрлэнэ. 2.10. Овоолох процесс

2.11. Цахилгаан хангамж

Цахилгаан тоног төхөөрөмжийн байрлал цахилгаан дамжуулах шугам зэргийг уулын ажлын дэвсгэр зураг дээр харуулсан цахилгаан хангамжийн бүдүүвч. Шугам дээр буюу гүйдэл дамжуулах тоног төхөөрөмж дээр хүмүүс ажиллаж буй үед тэдгээрийн хувиарлах болон залгах, салгах төхөөрөмжийн бариул дээр "Бүү залга хүмүүс ажиллаж байна" гэсэн хориглох санамж тавьсан байна. Үйлдвэр албан байгууллагын цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу ажиллагсдын аюулгүй байдлыг хангах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авсан байна.

Барилга байгууламжийг аянганаас хамгаалах арга хэмжээг “Ил уурхайд барилга байгууламжийг аянганаас хамгаалах журам”-ийн дагуу гүйцэтгэнэ. 2.12. Усан хангамж
Орд ашиглалтын үед унд ахуйн усыг “Сэрүүн” ХХК-ний баллонтой цэвэр усаар зөөвөрлөн хангана.

2.12. Автозамын үндсэн элемент

Уурхайн дотоод замд хөрс болон элс-хайрга тээврийн автосамосвалын хөдөлгөөний дундаж хурд нь автосамосвалын овор, жин, замын ачаалал, хөдөлгөөний эрчим, аюулгүй байдал зэргээс хамаарч ачаатай үед дунджаар 15 км/цаг, хоосон чиглэлдээ дунджаар 25 км/цаг байхаар сонгож тооцсон. Ашиглалтын нийт жилүүдийн турш уурхайн зам нь авто тээврийг бүтээлтэй ажиллахад нөлөөлөх гол хүчин зүйл болдог. Иймээс уурхайн замд засвар үйлчилгээ байнга хийх шаардлагатай. Тээвэрлэлтийн үед үүсэх тоосыг тоноглогдсон авто машинаар тогтмол усалж чийглэнэ.

БҮЛЭГ 3. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг баталгаатай байлгах зорилт тавьж ажиллана.

Газрын гадарга:

- Овоолго зам талбай бусад байгууламжаар газрын гадарга өөрчлөгдөх,
- Уурхайн ухаш, овоолго үүсэхэд газрын хэвлий эвдэгдэх,
- Газрын хэвлийд үүсэх орон зай нь мал амьтан аюултай байдал үүсэх.

Агаарын чанар:

- Ашиглагдах тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээс ялгарах нефтийн бүтээгдэхүүн, шатах тослох материалын ууршилт, автомашины хөдөлгүүрээс ялгарах хорт нэгдлүүд нь агаарыг бохирдуулах,
- Элс-хайрга олборлох, хөрс хуулах, тээвэрлэлтийн явцад агаарт тоосжилт үүсэх,
- Уурхайн олборлолт, тэсэлгээний үйл явц, овоолгын талбайгаас салхинд хийсэх тоос шороо агаарыг байнга бохирдуулах,
- Олборлолт тээвэрлэлтийн явц, овоолгоос үүссэн тоос шороо агаарт тархаж агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлэх.

Хөрсөн бүрхэвч:

- Барилга байгууламж байгуулах, ил уурхайн үйл ажиллагааны явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөх.
- Бүтээн байгуулалт болон барилгын чулуу олборлолтын явцад хүнд даацын машин, техникийн хөдөлгөөний улмаас өнгөн хөрс антропогени нөлөөлөлд өртөн, эрүүл талбай хөрсний овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүсэх,
- Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулах,
- Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүсэх,
- Хөрс эвдэрч физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах,
- Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах.

Ургамлан нөмрөг:

- Тоосжилт үүссэнээс ургамал ба ургамлын бүрхэвч дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

- Олборлолт, барилга байгууламж зэргээс газрын ургамал бүрмөсөн устана.
- Олон салаа зам, машин техникийн замбараагүй зорчих нь сөргөөр нөлөөлнө.

Амьтны аймаг:

- Олборлолтоос үүдэн мал амьтан үргэн дайжих,
- Уурхайн ухааш хоосон орон зайд мал амьтан унаж, бэртэх,
- Амьтан устах, дайжих, орчин тохигүйтэх зэрэг сөрөг өөрчлөлт нөлөөллөөс үүдэн амьтны аймаг нь аль нэг хэмжээгээр зайлшгүй гардаг. Жижиг мэрэгчээр хооллодог хөхтөн, шувууд тэжээлээ дагаж зурвас нутгийн орчноос холдоно.

Нийгэм эдийн засаг:

- Уурхайн үйл ажиллагааны улмаас гарах тоосжилт, ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдал, тоос шороо, чимээ шуугиан,
- Технологийн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушиг болон амьсгалын замын эрхтэнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болдог. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ,
- Ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Анто Од" ХХК-ийн Дархан-Уул аймгийн Орхон сумын нутагт орших "Их булан" элс хайрганы ордыг ил аргаар ашиглах" төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" Монгол Улсын хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 дугаар тушаалын "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

- ✚ Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- ✚ Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
- ✚ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- ✚ Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө
- ✚ Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө
- ✚ Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- ✚ Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- ✚ Хогхаягддын менежментийн төлөвлөгөө
- ✚ Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь
- ✚ Эрсдлийн менежментийн төлөвлөгөө
- ✚ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргээс бүрдэнэ.

“Дарханы Элс-хайрганы ордын Их буланын хэсгийн Элс-хайрганы орд” нь 2024 онд 7 сарын хугацаанд олборлолт явуулна. БОМТ-нд 2024 онд нийт **1,730,000** төг зарцуулахаар урьдчилсан байдлаар төлөвлөсөн ба үүнээс илүү зардал гарах тохиолдолд компаний дотоод зардлаас гаргах болно. Иймд байгаль орчныг хамгаалах ажлын барьцаа хөрөнгө нь төлөвлөсөн ажлын нийт зардлын 50 %-тай тэнцэх хэмжээний зардал төсөв буюу 865,000 төгрөг байхаар байна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, Мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох,	Төслийн талбайн байршилд	м ³	-	-	-	2024	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2		Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч байх;	Төслийн талбайн байршилд	тоо	3,500	-	3,500	2024	
3		Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, замыг хусаж байх	Төслийн технологийн зам дагуу	км	Үйл ажиллагааны зардалд		-	2024	
4		Агаарын чанарт муугаар нөлөөлөх авто тээврийн	Хүнд механизмууд, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг байнга хийж, утааны	Төсөлд ашиглаж буй техник хэрэгслүүдэд	тоо	2,800	-	2,800	

	хэрэгслийн утааны хэмжээг бууруулах	яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх					
5	Агаарын бохирдлын улмаас уурхай дахь ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт	Ажиллах хугацаанд бүх хүнд	тоо	ҮАЗ-д		
Хөрсөн бүрхэвч							
6	Хөрсөн бүрхэвчийн бохирдлыг бууруулах	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулж, хог хаягдлыг цаг тухай бүрт нь тээвэрлүүлэх	Төслийн талбайн байршилд	тоо	Сар бүр үйл ажиллагааны зардлаас	2024	Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
7		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн талбайн байршилд	тоо	Эрсдэл гарсан тухай бүрт байгууллагын дотоод зардлаар	2024	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
	Хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх	Тээврийн хэрэгслэлийг зориулалтын технологийн замаар явуулах	Орон нутгийн зам болон төслийн талбайд	м2	Дотоод төлөвлөлтөөр	2024	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Усны чанар							
10	Гүний усны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх ба гүний усанд нөлөөлөх байдлаас урьдчилан сэргийлэх	Усны хэмжээ, чанарыг хянах, хяналтын цооногийг талбайн зүүн захад суурилуулах; (48°36'46.29"N, 111°47'53.61"E)	Төслийн талбайн байршилд	тоо	Уурхайн дотоод зардлаар	2024	Хог хаягдлын тухай хууль, Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
11		Ахуйн хэрэглээний усыг ил задгай асгахгүй байх арга хэмжээ авах	Төслийн талбайн байршилд	м ³	Дотоод төлөвлөлтөөр	2024	MNS ISO 16075-/1,2,3,4/ 2018 Цэвэрлэсэн хаягдал усыг усалгаанд ашиглах гарын авлага. 1-р хэсэг: Ус дахин ашиглах төслийн үндсэн шаардлага
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний нийт зардал					7,300,000 төгрөг		

4.2. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд өмнөх оны байгаль орчны биелэлтийн тайланг дүгнэх хурлын үеэр Дархан сумын 5-р багийн нутагт техникийн нөхөн сэргээлт хийхээр орон нутагтай харилцан зөвшилцөөд байна.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Төлөвлөгөөт ажил	Талбайн хэмжээ	Зардал	Тайлбар
1	Дархан сумын 5-р багийн нутагт орон нутгаас зааж өгсөн талбайд нөхөн сэргээлт хийх	3 га	1,000,000	Орон нутгаас өгсөн талбайд нөхөн сэргээлтийн ажил хийх тул зардал тодорхой бус байна
Нийт		3	1,000,000	


Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд

Хүснэгт 6. Мод тарих талбайн координат

Цэгийн дугаар	Солбицлууд	
	Уртраг	Өргөрөг
1	105° 55' 21.32"	49° 30' 1.79"
2	105° 55' 26.80"	49° 30' 3.66"
3	105° 55' 31.46"	49° 29' 57.16"
4	105° 55' 29.52"	49° 29' 56.80"
5	105° 55' 25.72"	49° 30' 2.63"
6	105° 55' 22.54"	49° 30' 1.11"

Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршлын хажууд байрлах хуучин хогийн цэг байдлаар ашиглаж байсан талбайн нийт орчинд тархсан хогийг ковш болон бульдозер ашиглан түрэлт хийн цэвэрлэж тухайн орчныг шимт хөрсөөр хучсан бөгөөд одоогоор тус талбайд байгалийн жамаараа олон наст ургамал ургаж байна.

№	Агуулга	Зорилго	2024 онд гарах зардал
1	2022 оны нөхөн сэргээлт хийсэн талбайд мод нэмж тарих	100 ширхэг мод	100,0
Нийт зардал		100,0	



Зураг 2. Мод тарьсан талбай ба түүний байршил

4.3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

“Анто Од” ХХК-ийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсдын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллана.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ба түүний зардал

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Аюулгүй ажиллагааг хангах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төсөлд ашиглаж буй техникүүдэд	Дотоод зардлаар			2024	MNS 4598 : 2020 Автомтээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага
2	Гал түймрээс урьдчилан сэргийлэх	Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	ХАБЭА-ийн ажилтан нийт ажилчдад	1,500,000			2024	MNS 5566:2020
3	Аваар ослоос урьдчилан сэргийлэх	Хүчтэй салхи шуурганы үед уурхайн ажлыг түр зогсоох	Төслийн үйл ажиллагаанд	-	Дотоод төлөвлөлтөөр		2024	-
4	Ажлын байранд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Төслийн нийт ажилчдад	ХАБЭА-ийн ажилтны цалингийн зардлаас			2024	MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
5	Ажилчдыг ажлын байрандаа эрсдэлгүй ажиллах чадвар, мэдлэг суулгах	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Төслийн нийт ажилчдад	1 удаа	Компаний дотоод зардлаар		2024	MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага
Осол эрсдлийн менежмент төлөвлөгөөний нийт зардлын хэмжээ				1,500,000				

4.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдал нь ахуйн хатуу хог хаягдал (хуванцар сав, шил, лааз, цаас, сав, баглаа боодол, ахуйн хэрэглээ гэх мэт), шингэн хаягдал (уурхайн хотхоны хэрэглээнээс хаягдах бохир ус, хоолны газар, усанд орох газар гэх мэтээс гарах бохир ус гэх мэт), аюултай хог хаягдал (хэрэглэсэн шатах тослох материал, тээврийн хэрэгсэлээс гарах дугуй, резин, ашигласан зай гэх мэт)-ын сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой ажиллана.

Хүснэгт 8. Төслийн үйл ажиллагаа явуулах талбайн хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Хог хаягдлаас эвгүй үнэр гарч	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган	Төслийн байршилаас	тоо	500,000		2024 онд	Хог хаягдлын тухай хууль

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМАНД “ИХ БУЛАН” НЭРТЭЙ ГАЗАРТ ОРШИХ
ЭЛСНИЙ ОРД ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	орчныг үнэрийн бохирдолд оруулахгүй байх	цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	хогийн төвлөрсөн цэг рүү					MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
2	Аюултай хог хаягдлыг төслийн талбайн байршлаас зайлуулах	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төслийн талбайн байршилд	тн	Хэрэглээний хэмжээгээр			Аюултай, хортой хог хаягдлыг тээвэрлэх, устгах боловсруулах журам
3	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Аюултай хог хаягдлыг зориулалтын газарт хадгалж, аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	Төслийн талбайн байршил	Тоо	Дотоод зардлаар		2024 онд	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
4		Хог хаягдлын хор уршиг, ангилаан ялгах талаар ажиллагсад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Төслийн талбайн байршил	тоо	1,500,000		2024	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт зардал						2,000,000		

4.5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний үр дүнг дээшлүүлэхэд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр чиглэгдэнэ.

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ба түүний зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
	Хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосжилт	Төслийн талбайн байршилд	5, 8 саруудад	2 удаа	40,000	80,000	Төслийн талбайн байршилд ялгарч буй эсвэл гаднаас орж ирж буй бохирдол үүсгэгч хүчин зүйлийг хянах зорилготой	Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага: MNS 4585:2007 MNS 4048-88. Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга. MNS 3384-82. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 12.055-91. Ажлын байрны агаар дахь тоосны хэмжээг тодорхойлох Дэлхийн банк. Төрөл бүрийн ажлын орчин дахь дуу шуугианы хязгаарлалтууд, 2007.04.30
Хөрсөн бүрхэвч								
	Хөрсний ерөнхий агрохимийн шинжилгээ, хүнд металл	Төслийн талбайн байршилд	5, 8 саруудад	2 удаа	28,400	57,800	Төслийн үйл ажиллагаа явуулж буй	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5916:2008

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМАНД “ИХ БУЛАН” НЭРТЭЙ ГАЗАРТ ОРШИХ
ЭЛСНИЙ ОРД ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
							талбайн байршил дахь хөрсний бохирдлыг хянах илүү бохирдохоос урьдчилан сэргийлэх	“Ариун цэврийн тухай” хууль: 7-р зүйл: 7.4, 7.5 Дээжлэлт хийхдээ MNS: 3297:1991 MNS 3473:1983 MNS 4288:1995 MNS 5850:2008
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр					137,800 төг			

4.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Их булан нэртэй элсний орд олборлох төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд үүнд төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэн шаардлагатай арга хэмжээнүүд байхаар байна.

Хүснэгт 10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2	3	4	5	6	7	
	Байгаль орчныг хамгаалах тухай сургалт ажлыг зохион байгуулах	Байгаль орчны мэргэжилтний цалингийн зардлаар	-	-	-	Байгаль орчны мэргэжилэн	Байгаль орчны мэргэжилтний ажлын байрны онцлог нь байгаль хамгаалах төдийгүй бусад ажилчдыг өөрийн ажилд татан оролцуулах үүрэг, эрхийг хүлээдэг
	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны дотоод зардлаар	-	-	-	Компаний захирал удирдлагууд	
	Осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны	ХАБЭА-ийн ажилтны дотоод зардлаар	-	-	-	ХАБЭА-ийн ажилтан	Өөрийн ажиллаж буй нийт ажилчиддаа аюулгүй ажиллах орчин нөхцөлөөр хангах, өөрийгөө аливаа эрсдэлээс хамгаалж сургах нь ХАБЭА-ийн ажилтны үүрэг болно.
Удирдлага зохион байгуулалтын ажлын нийт зардал			Тухайн ажлыг хариуцсан ажилчдын төлөвлөлт болон цалингийн зардалд тусгагдсан				

4.7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Дархан сумын өөрийн харьяалал бүхий багийн иргэдийн нийтийн хуралд тайлагнах	Бичгэн болон танилцуулга хэлбэрээр /амаар/	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн талаар танилцуулж санал авах	9-р сард	Компанийн дотоод зардлаар	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Дархан сум
2	Дархан-Уул аймгийн Засаг даргын 2020 оны А/500 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг	Бичгэн болон танилцуулга хэлбэрээр /амаар/	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх	10-р сард	Компанийн дотоод зардлаар	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	Дархан-Уул аймаг
3	Тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох БОАЖЯ	Бичгэн тайлангийн хэлбэрээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнүүлэх, батлуулах	12-р сард	Компанийн дотоод зардлаар	Удирдлагууд болон БОМЭргэжилтэн	БОАЖЯ
Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө					-		

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Биелэлтийн зориулалт	Нийт зардал
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	7,300,000
2	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2024 онд хийгдэхгүй
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нийт зардал	1,000,000
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1,500,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,000,000
6	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	Дотоод зардлаар
7	Нөлөөллийн бүсийн иргэд, БОМТ-г сонирхогч талуудад танилцуулах	Дотоод зардлаар
2024 оны БОМТ-ний нийт зардал		11,800,000
Орчны хяналт шинжилгээний ажлын зардал		137,800